

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ LEGAL NECESSITY AND CONCEPT TO AMEND THE LAW ON COMBATING ALCOHOL ABUSE



Ч.Бат-Эрдэнэ. Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын мэргэжилтэн
Bat-Erdene.Ch. Officer of the Legal reform policy department, Ministry of Justice

Abstract: This article contains the goal to intensify and upgrade the activities on combating the alcohol abuse contained in the documents such as Mongolian National Security concept, the Government action plan of the years 2012-2016, its implementation plan, Mongolian President's initiative and action plan. By this article, I aimed to define its harm and impact, analyze the crimes entailing from the alcohol abuse, administrative offences, statistical survey of the traffic accidents, its reasons, alcohol drinks manufacturing, import, export, consummation, trade and service. Based on these research and analyses jobs I have mentioned about the project concept, new amendments and arrangements to convert the Law on combating the alcohol abuse to Anti-alcohol law.

Нэг. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг шинэчлэх үндэслэл, шаардлага:

1.1. Эрх бүхий байгууллагаас батлан гаргасан бодлого:

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.3.4-т "... архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна" хэмээн заасан билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн¹⁶ дөрөвдүгээр бүлгээр "спиртийн үйлдвэрлэлд тавих төрийн хяналтыг нэмэгдүүлэх, архидалт зохион байгуулдаг явдлыг таслан зогсоож, төсвийн мөнгөөр архи, согтууруулах ундаа худалдаж авахыг хуулиар хориглох, согтууруулах ундааны хатуулаг болон савлагааны хэмжээг бууруулах бодлого баримтлах, өндөр хатуулагтай согтууруулах ундааны татварыг үе шаттай нэмэгдүүлэх" зорилтыг дэвшүүлсэн юм.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга

хэмжээний төлөвлөгөөний¹⁷ 273-т "Согтууруулах ундаатай холбоотой хууль эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх талаар судалгаа хийнэ, спиртийн үйлдвэрт тавих төрийн хяналтыг сайжруулж, татварын хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх замаар өндөр хатуулагтай согтууруулах ундааны үйлдвэрлэлийг бууруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ, архи, спиртийн болон хүнсний бусад шингэний тоолуур шалгах зориулалттай суурин эталон тоног төхөөрөмж бүхий лаборатори байгуулна" гэж заасан.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2010 оны 12 дугаар сарын 31-нд **"Архигүй Монголын төлөө хамтдаа"** санаачилгыг дэвшүүлж, архидан согтуурах асуудалтай нийтээрээ тэмцэх шаардлагатай байгаа талаар уриалга гаргасан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009-2013 оны бодлого үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.2-т **"Монгол хүний удмын сан түүнд муугаар нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн талаар судалгаа явуулж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх"** тухай тусгасан байна.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай

¹⁶ Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан

¹⁷ Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан

хуулийн 15.8.1-т “уг хуульд олон нэмэлт, өөрчлөлт оруулах буюу үүний улмаас хуулийн үзэл баримтлал өөрчлөгдөх, бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орохоор бол хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна” гэж заасны дагуу Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Согтууруулах ундааны хяналтын тухай хуулийн төслийг боловсруулах шаардлага байв.

1.2. Согтууруулах ундааны зохисгүй хэрэглээтэй холбоотой гэмт хэрэг, захиргааны зөрчил:

Зах зээлд нийлүүлэгдэж буй согтууруулах ундааны хэмжээ, түүний хэрэглээ нэмэгдэж, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ нийгмийн түгээмэл үзэгдэл болсон нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэгдэх суурь шалтгаан, нөхцөл болж байна.

Статистикаас үзэхэд 2012 онд бүртгэгдсэн 22089 гэмт хэрэгийн 5063 нь, 2013 онд бүртгэгдсэн 25362 гэмт хэрэгийн 6406 нь согтуугаар үйлдэгдсэн байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 26.5 хувиар өсч, нийт гэмт хэргийн 25.2 хувь буюу **дөрвөн гэмт хэрэг тутмын нэг нь согтуугаар үйлдэгдсэн** байна.¹⁸ Бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт эзлэх согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоог харуулбал: Хүснэгт-1.

№	Үзүүлэлт	2012	2013	Өсөлт, бууралт	
				тоогоор	хувиар
1	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг	5063	6406	1343	+26.5
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	22.9	25.3	+2.4	

Нийт 5695 хүн согтуугаар гэмт хэрэг үйлдэж шалгагдсаны 49.5 хувь нь 18-29 насны, 5.9 хувь нь эмэгтэй, 1.9 хувь нь 16 хүртэл насны хүн бөгөөд нийт хэргийн 51.2 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 16.9 хувийг танхайрах, 11.3 хувийг хулгайлах, 4.6 хувийг тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 2.8 хувийг дээрэмдэх, 2.7 хувийг хүчиндэх, 2.2 хувийг хүнийг санаатай алах гэмт хэрэг тус тус эзэлж байна.


Дээрх статистикаас харахад 18-29 насны буюу залуусын дунд согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ өндөр байгаа нь харагдаж байна. 2013 онд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас 5602 иргэн хохирсоноос 263 хүн нас барж, 3809 хүн гэмтэж, 4.4 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

2013 онд бүртгэгдсэн 795923 захиргааны зөрчлийн **52499 зөрчил нь согтуугаар үйлдэгдсэн** буюу нийт


захиргааны зөрчлийн 6.5 хувийг эзэлж байна.

Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн тоог сүүлийн 5 жилээр харуулбал:

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг



Согтуугаар үйлдэгдсэн захиргааны зөрчил




Зам тээврийн ослын гол шалтгаан болсон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдал буурахгүй байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож гэмт хэрэг болон зөрчилд холбогдсон хүний тоог сүүлийн 5 жилээр харуулбал:

2013 онд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 123454 хүн эрүүлжүүлсэний дотор 63903 буюу 51.8 хувь нь нийслэлд, 55722 буюу 45.1 хувь нь аймгуудад, 3829 буюу 3.1 хувь нь төмөр замын салбарт тус тус эрүүлжүүлэгдэж, үйлчилгээний төлбөрт 449.2 сая төгрөгийг төлүүлсэн байна.

Хоногт дунджаар 338, үүнээс нийслэлд 175, аймгуудад 152 хүн эрүүлжүүлэгджээ. Манай улсын нийт хүн амын тоотой харьцуулахад давхардсан тоогоор 24 хүн тутмын нэг нь эрүүлжүүлэгдсэн дүн гарч байна.

Мөн тэдгээрийн 80632 буюу 65.3 хувь нь бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, 15293 буюу 12.4 хувь нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, 8160

¹⁸ Монгол Улс дахь 2013 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, Улаанбаатар хот 2014 он, Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл судалгааны төв



буюу 6.7 хувь нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас хаана байгаагаа болон очих газраа мэдэхгүй болсон, 12769 буюу 10.3 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, 4995 буюу 4.0 хувь нь гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй, 1605 буюу 1.3 хувь нь гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасны улмаас тус тус эрүүлжүүлэгджээ.¹⁹

2013 онд улсын хэмжээнд нийт эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн 6559 нь эмэгтэй, 833 нь 18 хүртэлх насны хүүхэд, 161 сурагч, 1358 оюутан, 1820 төрийн албан хаагч байгаа нь анхаарал татаж байна.

Дээрх статистик мэдээнээс харахад согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үүдэн гарах үндсэн шалтгаан, нөхцөл болж байгааг нотолж байна. Иймд согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг багасгахад чиглэсэн шийдвэртэй арга хэмжээ авах шаардлагатай байна.

1.3. Согтууруулах ундааны хэрэглээ ба эрүүл мэнд:

Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, татвараас хамаарч ажлын байр бий болж, төсөвт төвлөрөл хөрөнгө нэмэгдэж, эдийн засгийн үр өгөөж нэмэгдэж байгаа хэдий ч нийгэмд асар их хохиролыг учруулж байна. Согтууруулах ундаа биеийг хордуулж, сэтгэцэт мансууруулах нөлөө үзүүлж, донтолт үүсгэснээр эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хор хөнөөлийг бий болгож байна.

Дэлхийн нийт нас баралтын 3.8 хувь, хүн амын өвчлөл, осол гэмтлийн 4.65 хувь нь согтууруулах ундаанаас хамаарч байгаа бөгөөд, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна. Согтууруулах ундааны хэрэглээ нь зүрх судасны эмгэг, хөхны хорт хавдар, сүрьеэ, элэгний хатуурал, зам тээврийн осол гэмтэл, амиа егүүтгэх зэрэг эрүүл мэндийн тулгамдсан

асуудлын шалтгаан болж байна.

Мөн согтууруулах ундааны хэрэглээ нь нийгмийн олон тулгамдсан асуудлын эрсдэлт хүчин зүйл болдог. Хүчирхийлэл, гэр бүл салалт, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, ажилгүйдэл зэрэг нь согтууруулах ундааны хэрэглээтэй тодорхой хэмжээнд холбоотой болохыг анхаарах шаардлагатай байна.

Хүүхэд өсвөр үеийнхний дунд: 12-18 насны сурагчдын 26.5 хувь нь согтууруулах ундааг ууж үзсэн гэж хариулжээ. Эрэгтэй сурагчдын 68.4 хувь нь согтууруулах ундааг ууж үзсэн байдал нь эмэгтэйдээс 9.9 пунктээр илүү байна. Хотын сурагчдын 45.1 хувь хөдөөгийн сурагчдын 40.5 хувь нь 14 түүнээс доош насандаа согтууруулах ундаа хэрэглэж үзсэн байна. Нийт сурагчдын 8.9 хувь нь сүүлийн сард нэг ба түүнээс олон тоогоор согтууруулах ундааг хэрэглэсэн байна. Сурагчдын суралцдаг анги дээшлэхэд согтууруулах ундааг сүүлийн нэг сард хэрэглэсэн хувь статистик магадлал нэмэгдэж байна. Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 11.8 хувь нь согтууруулах төрлийн ундааг согтотлоо хэрэглэж үзсэн байна.²⁰

Насанд хүрэгсдийн дунд: Сүүлийн 30 хоногт ямар нэг хэмжээгээр архи хэрэглэсэн хувь хамгийн өндөр байсан (43.7%) насны бүлэг нь 25-34 насныхан бөгөөд согтууруулах ундааны өндөр хэрэглээтэй бүлэгт эрэгтэйчүүдийн 7.8 хувь, эмэгтэйчүүдийн 2.0 хувь, сүүлийн нэг сард согтууруулах ундааг их хэмжээгээр хэтрүүлэн ууж хэрэглэсэн байдал нийт хүн амын дунд 10.3 хувь байна.²¹

2012 оны байдлаар хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд нэгдүгээрт зүрх судасны тогтолцооны өвчин, хоёрдугаарт хавдар орж байна. Эдгээр хоёр өвчлөлд мөн согтууруулах ундаа хэрэглэх байдал нь шууд бусаар нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлс бөгөөд тархалтыг ихэсгэхэд нөлөөлж байна.

¹⁹ Монгол Улс дахь 2013 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, Улаанбаатар хот 2014 он, Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл судалгааны төв

²⁰ Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эрүүл мэндийн зан үйл судалгаа 2013. ЭМЯ, НЭМҮТ, ДЭМБ

²¹ Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа, 2013, ЭМЯ, НЭМҮТ, ДЭМБ, ММСС-ийн Эрүүл мэндийн төсөл

1.4. Сogтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, экспорт:

Улсын хэмжээнд 2013 оны байдлаар согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий спиртийн - 9, архины - 56, шар айрагны - 19, дарсны - 10, нийт 95 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байна. Мөн онд дээрх үйлдвэрүүд нь спирт 1.925.400 литр, архи, дарс 24.774.000 литр, шар айраг 63.775.300 литр бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийг төрөл тус бүрээр сүүлийн 5 жилээр харуулбал: /Литрээр/

Төрөл/ Он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Спирт	3.541.400	3.609.100	3.440.400	3.305.300	1.925.400
Архи	17.410.900	20.396.700	25.596.100	26.814.600	24.774.000
Дарс	-	-	122.800	79.800	78.300
Шар шайр	32.445.100	44.875.500	57.133.600	65.124.600	63.775.300
Нийт	-	-	86.292.900	95.324.300	90.553.000

“Монгол Улс 2014 оны 01 дүгээр сарын 20-ны байдлаар 2704526 иргэн, 2013 оны байдлаар 21-ээс дээш насны 1.770.519 суурин иргэн бүртгэгдсэн байна.”²² Нийт хүн амын тоонд 2013 онд нийт үйлдвэрлэсэн согтууруулах ундааны хэмжээг шууд харьцуулан үзвэл 1 хүнд 30.8 литр, 21-ээс дээш насны хүн амын тоонд шууд харьцуулан үзвэл 51 литр ногдохоор байгааг анхаарах шаардлагатай байна.

Мөн Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2013 онд согтууруулах ундааны үйлдвэрүүдэд Архидан согтуурахтай тэмцэх тухай, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай, Ургамал хамгааллын тухай зэрэг хууль тогтоомжийн хүрээнд шалгалт явуулахад шалгалтанд хамрагдсан үйлдвэрүүдийн 30% нь зориулалтын бус барилгыг хүнсний үйлдвэрийн зориулалтаар засаж тохижуулсан, 47.1% нь үйлдвэрийн байранд засвар хийх шаардлагатай болсон, 78.6% нь согтууруулах ундааг савлах шил, бөглөөг угааж ариутгасны дараа шинжилгээ хийх нян судлалын лабораторигүй, 10.5% нь архи, спиртийн үйлдвэрлэлийн оролтыг тоолууржуулаагүй, битүү хатуу холбоосоор холбоогүй, 57.2% нь бүтээгдэхүүний шошгонд мэдээллийг бүрэн тусгаагүй, шошгын зөрчилтэй, ажиллагсад сургалт явуулдаггүй, чанарын алба нь дотоодын хяналтын лабораторийн сорилтын үр дүнг үндэслэн бүтээгдэхүүндээ чанарын гэрчилгээ үйлдэн баталгаажуулж, худалдаа үйлчилгээнд гаргадаггүй нь тогтоогдсон байна.

Иймд согтууруулах ундааны үйлдвэрт стандартын өндөр шаардлага тавьж, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангасан согтууруулах ундаа

үйлдвэрлэх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Улсын хэмжээнд 2013 оны байдлаар 154926.5 литр согтууруулах ундаа экспортлосон бол, согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл бүхий 76 аж ахуйн нэгж нийт 36037239 литр согтууруулах ундаа импортлон оруулж ирсэн байна. Согтууруулах ундааны экспорт, импортын хэмжээг сүүлийн 5 жилээр харуулбал: /Литрээр/

Төрөл/ Он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Экспорт	73930.6	122959.5	57597.9	19198.0	154926.5
Импорт	11935571.4	21077965.6	25192185	32373066	36037239
Нийт	12009502	21200925.1	25249782.9	32392264	36192165.5

Монгол Улсын нийт хүн амын тоонд 2013 онд нийт импортлосон согтууруулах ундааны хэмжээг шууд харьцуулан үзвэл **1 хүнд 13.3 литр, 21-ээс дээш насны хүн амын тоонд шууд харьцуулан үзвэл 20.3 литр ногдохоор байна.**

Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас гаргасан судалгаагаар олон улсын түвшинд тогтоосон хэмжээгээр нэг хүний спиртийн жилийн хэрэглээ 6.1 литр бөгөөд, 8-9 литрт хүрсэн бол тухайн үндэстэн аюулд учирсан хэмээн үзсэнийг анхаарах нь зүйтэй байна.²³ Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импортын хэмжээ сүүлийн жилүүдэд жил дараалан өсч, тэр хэмжээгээр нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээ нэмэгдэж, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, согтууруулах ундаанаас үүдэлтэй өвчиллийн түвшин шууд хамаарч байна. Иймд согтууруулах ундааны үйлдвэрлэл, импортын хэмжээ өсөн нэмэгдэж, шинэ бүтээгдэхүүний төрөл олширч, маркетингийн нарийн арга эрчимтэй хөгжиж байгаа энэ үед согтууруулах ундааны хэрэглээнд согтууруулах ундааны үйлдвэрлэл, импортын хэмжээ улам илүү нөлөөлөж байгааг анхаарч төрөөс тодорхой арга хэмжээ яаралтай авах шаардлагатай байна.

1.5. Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ:

Улсын хэмжээнд 2013 оны байдлаар согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл бүхий 6823 аж ахуйн нэгж, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий 2880 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс орон нутагт согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл бүхий 4581, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий 1256, нийслэлд согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл бүхий 2242, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий 1624 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Нийслэлийн хэмжээнд согтууруулах ундаа

²³ Хууль зүйн үндэсний хүрээлэн, согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэхэд төрөөс тавих хяналт, хязгаарлалтын боломж сэдэвт судалгааны тайлан, 2010 он.

²² Үндэсний статистикийн хороо, <http://www.1212.mn/>, Сарын бюллетень, 2013 оны 12 дугаар сар.

худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжийн тоог сүүлийн 5 жилээр харуулбал: /Литрээр/

Төрөл/ Он	2009 ОН	2010 ОН	2011 ОН	2012 ОН	2013 ОН
Согтууруулах ундаа худалдах	2197	2352	2343	2358	2242
Согтууруулах ундаагаар үйлчлэх	1485	1326	1546	1593	1624
Нийт	3682	3678	3495	4009	3867

Нийслэлийн хүн амын тоонд нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжийн тоог харьцуулан үзвэл согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй 1 цэгт 397 хүн, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 1 цэгт 939 хүн ногдож байна.

Согтууруулах ундааны хүртээмж нэмэгдэхэд үүнийг дагаж хэрэглээ, нийгэмд учрах хор хөнөөл нь өсөн нэмэгддэг болохыг анхаарч хүртээмжийг хязгаарлах зохицуулалтын арга хэмжээ авах буюу согтууруулах ундаа зарах цаг, газрыг хязгаарлаж, согтууруулах ундаагаар үйлчлэх цэгийн тоог бууруулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Мөн Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2014 онд хийсэн шалгалтаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж, байгууллагууд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангаагүй, хаяг шошгын зөрчилтэй, гарал үүсэл, үйлдвэрлэсэн газар тодорхойгүй, үйлдвэрлэсэн хугацааг тавиагүй, хугацаа дууссан, дагалдах бичиг баримтгүй согтууруулах ундааг нийлүүлэгчээс хүлээн авч худалддаг болох нь тогтоогдсоныг анхаарч согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгт тодорхой шаардлагуудыг тавих нь зүйтэй байна.

1.6. Дэлхий дахины чиг хандлага:

Олон оронд залуу хүмүүсийн согтууруулах ундааны хэрэглээ санаа зовоосон асуудал болж залуу хүмүүс бага наснаасаа согтууруулах ундаа ууж эхэлж байгаагаас гадна хэтрүүлэн хэрэглэх нь нэмэгдэж байна. 2008, 2010 онд Дэлхийн эрүүл мэндийн ассамблейгаас согтууруулах ундааны хортой хэрэглээг багасгах нэгдсэн стратегийг баталсан бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалдгаагаар тогтоогдсон дараахь зохицуулалтыг стратегид тусгасан байна.

Согтууруулах ундаа худалдан авахад зөвшөөрөгдөх насны доод хэмжээг тогтоох, жижиглэн худалдаан дахь төрийн онцгой эрх, согтууруулах ундаа худалдах өдөр, цаг болон худалдааны цэгүүдийн нягтралд хязгаарлалт хийх, татварыг нэмэгдүүлэх зэрэг нь согтууруулах ундааны хэрэглээг багасгахад үр нөлөөтэй бодлого гэж үзсэн байна. Мөн боловсрол, итгэл үнэмшил зэрэг урьдчилан сэргийлэх стратеги

нь магадгүй өргөн хэрэглэгдэж болох боловч заавал үр дүн өгөхгүй байж болохыг анхуурлсан байна.²⁴

Хоёр. Хуулийн төслийн үзэл баримтлалын талаар

2.1. Согтууруулах ундааны үйлдвэрлэл:

Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр Засгийн газар олгоно. Мөн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох тухай шийдвэрийг улсын байцаагчийн дүгнэлт, тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар гаргахаар тусгана.

Согтууруулах ундааны үйлдвэрт тавих шаардлагыг нарийвчлан зааж өгнө. Тухайлбал:

- Хууль, үйлдвэрлэлийн стандарт, согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалтын шаардлагыг бүрэн хангасан байх;
- Үйлдвэрлэлд чанар, аюулгүй байдлын дотоод хяналт, удирдлагын тогтолцоотой байх;
- Үйлдвэрлэлийн дамжлагын болон түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний хяналтын итгэмжлэгдсэн сорилтын лабораторитой байх;
- Үйлдвэрлэлийн шугамын оролт, гаралтыг хянах зориулалт бүхий, хэмжлийн үр дүнг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шууд дамжуулах, тоолууржуулсан зориулалтын төхөөрөмжөөр тоногдсон байх;
- Хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлсэн бүтээгдэхүүний нууцлал бүхий бүртгэлтэй, буцаан татах тогтолцоотой байх.

2.2. Согтууруулах ундаа импортлох:

Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр Засгийн газар олгохоор, согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох шийдвэрийг улсын байцаагчийн дүгнэлт, тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар гаргахаар тусгана. Согтууруулах ундаа импортлох аж ахуйн нэгж, импортын согтууруулах ундаанд тавих шаардлагыг нарийвчилж, тухайн жилд импортлох согтууруулах ундааны хэмжээг зааж өгнө.

2.3. Согтууруулах ундаа худалдах:

1. Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг тухайн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, сум, дүүргийн Засаг даргын санал, мэргэжлийн хяналт, цагдаагийн албаны дүгнэлтийг үндэслэн сонгон шалгаруулалтын үндсэн дээр аймаг, нийслэлийн

²⁴ Архины хортой хэрэглээний тухай өгүүлэх нь, Архины талаар үр дүнтэй хууль тогтоомжийг боловсруулах талаархи гарын авлага, Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага, 2011 он.

Засаг дарга олгохоор тусгана.

Мөн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох шийдвэрийг тухайн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, сум, дүүргийн Засаг даргын санал, татвар, цагдаа, мэргэжлийн хяналтын албаны дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга гаргана.

2. Спиртийн өндөр болон спиртийн сулагууламжтай согтууруулах ундааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр дагнасан цэгээр худалдана. Энэ зохицуулалтын үйлчилж эхлэх хугацааг спиртийн өндөр болон спиртийн сул агууламжтай согтууруулах ундааны төрлөөр ялгамжтай тогтоож өгнө.

Согтууруулах ундаа худалдах дагнасан цэгийн тоо, байршлыг тухайн орон нутгийн 21-ээс дээш хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, орон сууцны хороолол, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршлыг харгалзан 2000 мянган хүн ам тутамд нэгээс ихгүй, 2000-аас доош хүн амтай суманд 2-оос дээшгүй байхаар тооцож аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтооно.

3. Согтууруулах ундаа худалдах дагнасан цэг дараах шаардлагыг хангасан байна:

- Үйлчилгээний газрын гадна болон дотор талбайг хянах боломжийг хангасан камерын хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- Согтууруулах ундааны нууцлалыг шалгах төхөөрөмж суурилуулах;
- Үйлчилгээний стандарт шаардлагыг хангасан байх.

4. Согтууруулах ундааг 10-22 цагийн хооронд зөвшөөрөгдсөн цэгээр худалдана. Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал дээрх хугацаанд багтааж тухайн орон нутагт согтууруулах ундаа худалдахгүй байх өдөр, цагийн хуваарийг тусгайлан тогтоож болно.

5. Согтууруулах ундаа худалдах зөвшөөрөлтэй газарт дараах зүйлийг хориглоно:

- Согтууруулах ундаа үйлдвэрлэхэд хэрэглэсэн түүхий эд болон түүнд ногдох онцгой албан татвар шингэсэн үнээс бага үнэтэй согтууруулах ундаа худалдах;
- Тээврийн хэрэгсэл жолоодож яваа, 21 нас хүрээгүй, сэтгэцийн эмгэг бүхий болон согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдэд согтууруулах ундаа худалдах;
- Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон аж ахуйн нэгжийн байршил дээр тусгай зөвшөөрөл шинээр олгох;
- Согтууруулах ундаа худалдах нэг тусгай зөвшөөрлөөр хоёр тусдаа үйл ажиллагаа явуулах;
- Нэг хуулийн этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд тухайн аймаг, нийслэлийн согтууруулах ундаа худалдаалах дагнасан цэгийн тусгай зөвшөөрлийн 25-аас дээш хувийг эзэмших.

2.4. Согтууруулах ундаагаар үйлчлэх:

1. Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг тухайн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, сум, дүүргийн Засаг даргын санал, мэргэжлийн хяналт, цагдаагийн албаны дүгнэлтийг үндэслэн сонгон шалгаруулалтын үндсэн дээр аймаг, нийслэлийн Засаг дарга олгохоор тусгана.

Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох шийдвэрийг тухайн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, сум, дүүргийн Засаг даргын санал, татвар, цагдаа, мэргэжлийн хяналтын албаны дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга гаргахаар тусгана.

2. Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл нь дараахь төрөлтэй байна:

- Өглөөний 10 цагаас шөнийн 00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл;
- Өглөөний 10 цагаас шөнийн 04 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл.

3. Тусгай зөвшөөрлийн агиллын дагуу согтууруулах ундаагаар шөнийн 00 цагаас өглөөний 10 цаг, шөнийн 04 цагаас өглөөний 10 цаг хүртэл үйлчлэхийг хориглоно. Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал дээрх хугацаанд багтааж тухайн орон нутагт согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх өдөр, цагийн хуваарийг тусгайлан тогтоож болно.

2.5. Согтууруулах ундааны хэрэглээнд тавих хяналт:

1. Согтууруулах ундаа хэрэглэх, худалдах, түүгээр үйлчлэхэд хориглох газруудыг тодорхой тусгана.

- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан болон үйлдвэрлэлийн байранд;
 - Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байр, эмнэлэг, сувиллын газрын орчны бүсэд;
 - Орон сууц, түүний орц, хонгилд;
 - Орон сууцны оршин суугчид, өмчлөгчдөд зориулагдсан сууц өмчлөгчдийн холбооны орчны газарт;
 - Гудамж, талбай, цэцэрлэгт;
 - Галт тэрэг, авто тээвэр, усан болон нисэх онгоцны буудлын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт;
 - Нийтийн тээвэр, хүнсний болон барааны зах, худалдаа үйлчилгээний газар зэрэг олон нийтийн газрын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт;
 - Шатахуун түгээх газар;
 - Үйлдвэрлэл, технологийн паркт.
 - Согтууруулах ундаа гар дээрээс болон цахим хэлбэрээр худалдахыг хориглоно.
2. Дараах зохисгүй хэрэглээг хориглоно.
- Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх, түүнчлэн 21 нас хүрээгүй хүнийг уруу татаж согтууруулах

ундаа уулгахыг хориглоно.

- 21 нас хүрээгүй хүнд согтууруулах ундаа хэрэглэх боломж олгохыг санаачилан зохион байгуулах, энэ зорилгоор орон байраар хангах, мөнгөн туслалцаа үзүүлэхийг хориглоно.
- Согтууруулах ундааг урамшуулал хэлбэрээр тараах, цалин хөлсийг орлуулж олгохыг хориглоно.
- Төрийн ёслолын үйл ажиллагаанд согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно.
- Төрийн байгууллага болон төсвийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь төсвийн хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авах, аливаа тэмдэглэлт арга хэмжээг согтууруулах ундаа хэрэглэн тэмдэглэхийг хориглоно.
- Төрийн албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа согтууруулах ундаа хэрэглэх боломжийг санаачилан зохион байгуулахыг хориглоно.
- Согтууруулах ундаа үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, борлуулах, худалдах, түүгээр үйлчлэх ажилд 18 нас хүрээгүй хүн авч ажиллуулахыг хориглоно;

2.6.Согтууруулах ундааны сурталчилгааг хориглох:

Согтууруулах ундаа, түүнийг үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа явуулж буй байгууллагыг аливаа төрөл, хэлбэрээр сурталчилах, хэрэглээг дэмжихэд чиглэсэн бүх төрлийн мэдээлэл түгээхийг хориглохоор тусгана.

2.7.Согтууруулах ундааны татвар, улсын тэмдэгтийн хураамжийг нэмэгдүүлэх:

Монгол Улсад үйлдвэрлэсэн нийт 132 нэр төрлийн архины 112 нь 37-40 градусын хатуулагтай спиртийн өндөр агууламжтай архины төрөлд хамаарч, нийт үйлдвэрлэсэн архины 68 хувийг 38 градусын хатуулагтай архи эзлэж байна. Иймд энэхүү градусыг нэг шатлалаар бууруулах зорилгоор Онцгой албан татварын тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

Мөн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, спирт үйлдвэрлэх, архи, шар айраг, дарс үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл олгох, сунгахад хураах улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг зохистой нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

2.8.Олон улсад түгээмэл хязгаарлалтын аргууд:

Согтууруулах ундааны хэрэглээ болон эрүүл мэнд, нийгмийн сөрөг үр дагаврын хоорондын хамаарлын талаарх шинэжлэх ухааны ойлгоход сүүлийн жилүүдэд томоохон ахиц гарсан бөгөөд бодлого боловсруулалт энэхүү шинэжлэх ухааны нотолгоонд тулгуурлах ёстой.

Согтууруулах ундааны зохистой бус хэрэглээг

хязгаарлах, үүсч буй сөрөг үр дагаврыг багасгахын тулд дараахь үр дүнтэй аргыг хэрэглэхийг олон улсын байгууллагуудаас зөвлөсөөр байна.

1.Согтууруулах ундааны үнэ болон татварын бодлогыг оновчтой болгох арга. Энэ арга нь согтууруулах ундааны эдийн засгийн өртгийг бусад бүтээгдэхүүнээс харьцангуй өндөр болгох нь эрэлтийг бууруулдаг.

2.Согтууруулах ундаа зарах цаг, газрыг хязгаарлах, согтууруулах ундаа зардаг газрын нягтралыг бууруулах замаар согтууруулах ундааны биет хүртээмжийг зохицуулах арга. биет хүртээмжийг хязгаарлах нь согтууруулах ундаа олж авахад зарцуулах хүчин чармайлтыг нэмэгдүүлж, согтууруулах ундааны хэрэглээ, түүнтэй холбоотой тулгамдсан асуудлыг бууруулна.

3.Согтууруулах ундаагаар үйлчлэх орчныг өөрчлөх.

Согтууруулах ундааны хэрэглээг хязгаарласан нийгмийн орчин бүрдүүлэх нь согтууруулах ундааны хэрэглээ, түүнтэй холбоотой хүчирхийллийг бууруулна.

4.Согтууруулах ундааны маркетингийг зохицуулах.

Согтууруулах ундааны хэрэглээг хэвийн үзэгдэл, нийгэм дэх байр суурийн баталгаа мэтээр сурталчилсан маркетингийг хязгаарлах нь залуучууд согтууруулах ундаа хэрэглэж эхлэх, хэтрүүлэн хэрэглэхээс сэргийлнэ.

5.Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохтой тэмцэх. Согтуугаар жолоо барихыг хориглох, шийтгэл ногдуулах, нийгмийн зүгээс дарамт шахалт үзүүлэх нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдлыг бууруулна.

Хууль зүйн яамнаас ажлын даалгавар өгч, согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх, түүний импорт, экспорт болон хэрэглээнд хяналт тавих, согтууруулах ундааны хэрэглээнээс үүссэн эрүүл мэнд, нийгмийн сөрөг үр дагаврыг бууруулахтай холбоотой 8 чиглэлээр гадаад улсын туршлагыг судалж, харьцуулсан бодлогын судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр мөн хийлгэсэн болно.